БАГАНУУР ХК

# "БАГАНУУР" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 19 өдөр Дугаар 03 Улаанбаатар

Ноголдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46.1, 46.2, 46.5 дахь хэсэг, 76.1.12 дахь заалт, "Багануур" ХК-ийн дүрмийн 2.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Багануур" ХК-ийн 2024 оны санхүүгийн үйл ажиллагааны цэвэр ашгиас 30 хувиар тооцож нийт 495,414,383.20 (дөрвөн зуун ерэн таван сая дөрвөн зуун арван дөрвөн мянга гурван зуун наян гурван төгрөг хорин мөнгө) төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилахаар тогтоосугай.

2.Нэгж хувьцаанд 23.62 (хорин гурван төгрөг жаран хоёр мөнгө) төгрөгийн ногдол ашиг тараахыг "Багануур" ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/-д даалгасугай.

3.Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг бүртгэх өдрөөр тогтоосугай.

4.Ногдол ашгаас хууль тогтоомжийн дагуу холбогдох татварыг суутган тооцож, 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулсугай.

5.Энэ тогтоолын хэрэгжилтийг зохион байгуулж, хуульд заасан зохих арга хэмжээ авч ажиллахыг "Багануур" ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч /Д.Түвшинжаргал/-д үүрэг болгосугай.

6.Ногдол ашиг хуваарилсан тухай шийдвэр, ногдол ашиг тараасан талаарх тайланг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо /Б.Чойжил/-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ч.ДОНДОГМАА